



БАТЛАВ:ХАТАНБУЛАГ СУМЫН
ЗАСАГ ДАРГА **С.ЭРДЭНЭБОЛД**

ХАТАНБУЛАГ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2019 оны 06 дугаар сарын 13-ний өдөр

**Төслийн нэр: “ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЦАХИЛГААНЫ МОНТАЖЫГ
ШИНЭЧЛЭХ” АЖЛЫН ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ**

Төслийн дугаар: ХБ-ХА-2019/04

Хатанбулаг сум

2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендер зарлах огноо: 2019-06-13

Хатанбулаг сумын ЗДТГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Эрүүл мэндийн төвийн монтажыг шинэчлэх” тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны стандарт, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг *2019 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн 14 цаг*-аас өмнө *Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 203 тоот Засаг даргын орлогч гэсэн* хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан *2019 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн 14 цаг 30 минутанд* нээнэ.

Тендерийн баримт бичгийн үнэ болох 30.000 төгрөгийг Төрийн сан банк 100061055406 ЗДТГ нэмэлт санхүүжилт гэсэн дансанд тушаан тендерийн баримт бичиг авна.

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газар
Утас: 95514343
Имейл:zulchimedtseren@yahoo.com

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Оролцогч компанийн танилцуулга
 - (в) Бараа нийлүүлэх хуваарь;
 - (г) Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг;
 - (д) Ижил төрлийн бараа, нийлүүлсэн туршлага гэрээ холбогдох тайлангийн хуулбар;
 - (е) Шаардлагатай тусгай зөвшөөрөл “Цахилгаан угсралт, засвар үйлчилгээ хийх”
 - (ё) -Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар
-Тусгай зөвшөөрлийн баталгаажсан хуулбар
 - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл
 - Харьяалагдах банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх
 - Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх
 - Гэрээг гүйцэтгэгч удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл
 - Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагын мэдээлэл
4. Тогтмол үнэ
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.

5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
- 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
- 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь *ТШӨХ-д* заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТООЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТООЗ 1.1	Сүүлийн <i>1</i> жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/; Сүүлийн <i>2</i> жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/; Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Цахилгаан угсралт, засвар үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөлтэй.
ТООЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: <i>Хатанбулаг сум 5-р баг ЗДТГ</i> Давхар болон өрөөний дугаар: <i>Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2 давхарт 203 тоот өрөө</i> Огноо: <i>2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр</i> Цаг: <i>14 цаг 00 минут</i>
ТООЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: <i>Хатанбулаг сум 5-р баг ЗДТГ</i> Давхар болон өрөөний дугаар: <i>Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2 давхарт 203 тоот өрөө</i> Огноо: <i>2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр 14 цаг 30 минут</i> Цаг: <i>14 цаг 30 минут</i>
ТООЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:” Эрүүл мэндийн төвийн монтажыг шинэчлэх” ХБ-ХА-2019/04

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Эрүүл мэндийн төвийн дотор цахилгааны засвар, шинэчлэлийн
ажлын техникийн тодорхойлолт

1. Эрүүл мэндийн төв, мооргийн гадна оролтийн кабелийг шинэчилж 3 фазын тоолуур, автомат тавих / Гадаа шитний хайрцагт/
2. Бүх өрөө, плат, фестүл, коридорын монтажийг шинэчлэн хуванцар хоолойгоор далдлах./нийт 41 өрөө/.
3. Монтажны утас нь зэс голтой 3x4мм голчтой 2x2.5мм² огтлолтой утасаар монтажыг шинэчлэх.
4. Бүх өрөө коридорын гэрэл, разетка, унтраалгыг шинэчлэх.
5. Бүх өрөөнд нэмэх, хасахтай лед гэрлийг өрөөний зай талбайн хэмжээгээр тохируулан суурьлуулах.
6. Гал тогоо, архивын өрөөнд бүрхүүлтэй улайсах ламптай гэрэл тавих.
7. Гал тогооны өрөөнд 380v-ын разетка 2 ширхэгийг тавих.
8. Платны өрөөнүүдэд өвчтөний ор бүрийн толгой дээр гэрэл, унтраалга, разетка тавих./ 8 өрөөнд тус бүр 16 ширхэгийг/
9. Цогцос хадгалах байр буюу мооргийн гэрлийг лед гэрлээр солих.
10. ЭМТөвийн эрхлэгчийн өрөөнд гоёлын абжуртай лед гэрэл 1ш

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

НАРИЙН БИЧИГ

ГИШҮҮД

З.ЧИМЭДЦЭРЭН

Т.УУГАН-ЭРДЭНЭ

Т.СОЁЛ-ЭРДЭНЭ

Д.БУЯНЦЭЦЭГ

П.САЙНБУЯН

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших

1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт

2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх

3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх

4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа

5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [3] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах

6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр

7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [Ажлын 15] хоногийн дотор шуурхай хийнэ.

- | | |
|--|--|
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: <ul style="list-style-type: none"> 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт; 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ; |

5) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

3. Баталгаат засвар (ГЕН-5)

5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

[3 жилийн баталгаат хугацаатай байна]

4. Төлбөр (ГЕН – 7)

7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹

9.1. Алданги оногдуулах хувь: **[0.5%]**

Алдангийн нийт дүн: **[10%]**

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас ***[захиалагчийн нэр]*** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас ***[нийлүүлэгчийн нэр]*** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь ***[гэрээний нэр, дугаар]***-г (цаашид “бараа” гэх) ***[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]*** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-наас _____ оны __ дугаар сарын __-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг²;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

*[Гарын
үсэг]* _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

